



ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН
ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ДААЛГАВАР

2023 оны 03 сарын 01 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Бүртгэл хөтлөх тухай

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.14 дэх хэсэгт заасан мэдээлэл хариуцагч хязгаарлалттай мэдээллийг ашиглах хүсэлт гаргасан, гуравдагч этгээдэд өгсөн, дамжуулсан талаарх бүртгэл хөтөлж ажиллах зорилгоор төв болон орон нутаг дахь нэгжийн дарга нарт ДААЛГАХ НЬ:

Нэг. Төв болон боомт, орон нутаг дахь нэгжийн дарга нарт дараах үйл ажиллагаа, хуулийн хэрэгжилтийг ханган, хяналт тавьж ажиллахыг үүрэг болгосугай.

1.1. Мэдээлэл солилцооны бүртгэлийн систем ашиглалтад орох хүртэл хугацаанд хязгаарлалттай мэдээлэл ашиглах хүсэлт гаргасан, гуравдагч этгээдэд дамжуулсан талаарх бүртгэлийг хууль тогтоомжид заасан мэдээллийг тусгаж, ангилан төрөлжүүлэн бүртгэж хэвших;

1.2. Хязгаарлалттай мэдээлэл ашиглах хүсэлт гаргасан бүртгэлийг өргөдөл, гомдол, архив-бичиг хэрэг хариуцсан албан хаагч, хязгаарлалттай мэдээллийг гуравдагч этгээдэд дамжуулсан талаарх бүртгэлийг нэгжийн дотоод зохион байгуулалт хийж, хариуцуулах;

1.3. Бүртгэлийг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нөхөн бүртгэж, биелэлтийг сар, улирал, хагас жил, жилийн эцсийн нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд тусган Захиргаа, удирдлагын газарт тайлагнах;

Хоёр. Албан даалгаврын хэрэгжилтийг хангахад Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль болон Засгийн газрын 2022 оны 211 дүгээр тогтоолоор баталсан Хязгаарлалттай мэдээллийг өгсөн, дамжуулсан тохиолдолд мэдээллийн эзэнд мэдэгдэл хүргүүлэх, ашиглах хүсэлт гаргасан, гуравдагч этгээдэд өгсөн, дамжуулсан талаарх бүртгэл хөтлөх журам, холбогдох бусад хууль тогтоомжийг мөрдөж ажилласугай.

Гурав. Хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан бүртгэлийн дэвтрийн загвар боловсруулж, энэ даалгаврын хавсралтаар хүргүүлэх, мэдээллээр ханган ажиллахыг Захиргаа удирдлагын газар (Д.Давааням)-т даалгасугай.

Дөрөв. Албан даалгаврын биелэлтэд хяналт тавьж, удирдлагаар хангаж ажиллахыг Захиргаа удирдлагын газар (Д.Давааням), Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс (З.Өнөрсайхан)-т тус тус үүрэг болгосугай.

Хавсралт ... хуудастай.

ДАРГА

Н.УУГАНБАЯР



170000813

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын
2023 оны 05 дугаар сарын 01 -ны өдрийн
01... дугаар албан даалгаврын 1 дүгээр хавсралт

ХЯЗГААРЛАЛТТАЙ МЭДЭЭЛЛИЙГ ГУРАВДАГЧ ЭТГЭЭДЭД ӨГСӨН,
ДАМЖУУЛСАН ТАЛААРХ БҮРТГЭЛ

№	Хүсэлт гаргасан этгээдийн мэдээлэл	Мэдээллийг өгсөн, дамжуулсан огноо	Мэдээллийн эзнийг тодорхойлох мэдээлэл	Мэдээллийн эзний зөвшөөрөл өгсөн хэлбэр	Зөвшөөрлийн баталгаажуулалтын огноо	Хүсэлт гаргагчийг цахим тодорхойлогчоор тогтоосон тодорхойлолт	Байгууллага, албан тушаалтны мэдээлэлд хандсан огноо
0	1	2	3	4	5	6	7
1.							

Үргэлжлэл

Авсан мэдээллийн агуулга	Мэдээлэл авсан зорилго	Мэдээлэл ашигласан гуравдагч этгээдийн нэр, албан тушаал, утасны дугаар	Мэдээллийг бүрэн, эсхүл хэсэгчлэн өгсөн эсэх	Өгсөн, дамжуулсан мэдээллийн жагсаалт, мэдээлэл авсан хэлбэр	Мэдээллийн эхнээс зөвшөөрөл аваагүй тохиолдолд хууль зүйн үндэслэл	Шардлагатай бусад
8	9	10	11	12	13	14

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын
2023 оны 03 дугаар сарын 01-ны өдрийн
01 дугаар албан даалгаврын 2 дугаар хавсралт

ХЯЗГААРЛАЛТАЙ МЭДЭЭЛЭЛ АШИГЛАХ ХҮСЭЛТИЙН БҮРТГЭЛ

№	Хүсэлт гаргасан хүн, хуулийн этгээдийн нэр, харилцах утасны дугаар, хаяг	Хүссэн мэдээллийн товч агуулга, зорилго	Хүсэлт хүлээн авсан он, сар, өдөр, хэлбэр	Хүсэлтийг буцаасан тохиолдолд үндэслэл, хэлбэр	Хууль зүйн үндэслэл	Шаардлагатай бусад
0	1	2	3	4	5	6
1.						